

“БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ” ТӨРИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИ

ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын нэр:

110/35/10 кВ Бэрх дэд станцад тоноглол
суурилуулах ажлыг гүйцэтгэх
гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах

Тендер шалгаруулалтын дугаар:

Т-ХА№19/28

Хаяг:

Улаанбаатар хот Багануур дүүрэг
үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦС”
ТӨХК-ний конторын байр

Утас:

99022755

Факс:

70210167

НЭГ. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

“БЗӨБЦТС” ТӨХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Т-ХА19/28 дугаартай 110/35/10 кВ Бэрх дэд станцад тоноглол суурилуулах ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар. www.tender.gov.mn төрийн худалдан авах ажиллагааны цахим системд нэвтэрч авна уу

Дотоодын давуу эрх тооцох эсэх.-үгүй

Хаяг : Улаанбаатар хот Багануур дүүрэг үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС” ТӨХК-ний конторын байр 202 тоот өрөө.

Утас: 99022755. 99990383

Факс: 70210167

Нэг. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

1. Эрх бүхий тендерт оролцогч
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө www.tender.gov.mn цахим хаягаар хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар www.tender.gov.mn цахим хаягаар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маятуудыг нууцлахгүй ирүүлнэ.
3. Тендерийн иж бүрдэл
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлэс бүрдэнэ:
 - (а) Унийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) ТШӨХ-д заасан заалтууд
4. Тендерийн үнэ
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтаасан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстай бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
5. Унийн саналын хүчинтэй байх хугацаа
 - 5.1. Унийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
6. Алдааг залруулах
 - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:

- (a) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцгчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Хоёр. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт /Бүрдүүлэх материал/
ТОӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар 2. Үнийн санал /маягтын дагуу/ 3. НӨАТ төлөгч бол гэрчилгээний хуулбар, НӨАТ биш бол энэ тухай албан бичиг ирүүлэх 4. 2018 оны борлуулалтын орлого тендерийн төсөвт өргөөс баагүй байна. /Сангийн сайдын 2013 оны тушаалын хавсралт “Цахим тендер зохион байгуулах журмын 1.2 дахь заалтын дагуу цахим тендерийн лавлагааг үндэслэн/ 5. Одоогийн ба сүүлийн 3 жилийн хугацаанд шүүхийн ямар нэгэн зарга маргааны талаарх тодорхойлолт. /Шүүхийн төрөлжсөн архив, Шийдвэр гүйцэтгэх албанаас тус тус ирүүлэх/ 6. Тендер нээсэн өдрийн байдлаар татварын өргүй байх /Татварын тодорхойлолтыг www.tender.gov.mn цахим сайтын тендерийн лавлагааг үндэслэн/ 7. Гүйцэтгэх ажил болон бусад шаардлага нь захиалагчийн техникийн тодорхойлолтын шаардлагыг хангасан байх 8. Ажил гүйцэтгэх машин механизм нь шинэ, шинэвтэр /2007 оноос хойш үйлдвэрлэгдсэн/ байна. 9. Тендерт оролцогч нь ГТН 19.1-р заалтыг хүлээн зөвшөөрсөн албан бичиг ирүүлэх. <p>Дээрх баримт бичгийг бүрдүүлж ирээгүй тохиолдолд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27.1.3 дугаар зүйлийн шаардлагыг хангаагүй гэж үзэн ирүүлсэн тендерээс татгалзана.</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.</p> <p>Огноо: Тендерийг 2019 оны 09 дугаар сарын 04-ний өдрийн 16 цаг 00 минутаас өмнө цахим системээр илгээх.</p>
ТОӨЗ 2.2	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Нээлтийг 2019 оны 09 дугаар сарын 04-ний өдрийн 16 цаг 30 минутаас цахим системээр илгээн.</p> <p>УБ хот Багануур дүүрэг 3-р хороо үйлдвэрийн хэсэг “БЗӨБЦТС” ТӨХК-ийн өөрийн байр, 2-р давхар 202 тоот өрөө 99022755</p>
ТОӨЗ 7.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий байна:</p> <p>T-XA№19/28 110/35/10 кВ Бэрх дэд станцад тоноглол суурилуулах ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг Багцтай эсэх: Угүй</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Шаардлага	Техникийн үзүүлэлт, тайлбар
1	Ерөнхий шаардлага	<ul style="list-style-type: none"> • Энэхүү ажил нь материал нийлүүлэлтээс хамаарч 3 сараас дээш хугацаагаар үргэжлэх тул захиалагчийн баталсан үе шатны графикт нийцүүлэн, газар шорооны ажлыг жигд хуваарилан зохион байгуулна. • Захиалагчийн шаардсан хуанлийн хугацаанд газар шорооны ажлыг тасралтгүй хийж гүйцэтгэх ба ажлыг бүрэн дууссаны дараа захиалагчид хүлээлгэн өгнө. • Захиалагчийн баталсан ажлын хуваарийн дагуу ковш нь ажлын байранд тогтмол ажиллана. • Гүйцэтгэгч компани өөрийн ажилчдын хоол, амрах байрыг ажлын талбайд зохион байгуулж хариуцна. • Цаг уурын хүндрэлтэй нөхцлөөс хамаарсан хугацааг захиалагчтай зөвшилцөж ажил гүйцэтгэх хугацаанаас тооцож болно. • Ковшт гарсан эвдрэл, гэмтлийг засварлах ажлыг шуурхай зохион байгуулж, зардлыг гүйцэтгэгч тал хариуцна. • Захиалагчийн ажлын удирдагчаас өдөр бүр тогтмол зааварчилгаа авч ажиллана. • Тулгуурын нүх, суурийн нүх, дэд станцын суурийг ухах, булахдаа ажлын зургийн дагуу техникийн шаардлагад заасан хэмжээгээр бүрэн гүйцэд булна. • Ковшийн операторчин Замын хөдөлгөөний дүрэм, ХАБЭА-ийн хууль дүрмийг чанд мөрдөж, осол зөрчилгүй ажиллахыг гүйцэтгэгч компани хариуцна. • Ковш нь гүйцэтгэгч компанийн өөрийн өмчлөлийнх байна. /Түрээсийн байхыг зөвшөөрөхгүй/ • Ковш нь шинэ, шинэвтэр /2010 оноос хойш үйлдвэрлэгдсэн/, 220 морины хүчин чадалтай, шанаганы хэмжээ нь 3 м³-аас доошгүй байна. • Гүйцэтгэгч нь өдөр бүр хийгдсэн ажлын мэдээг өгч, гүйцэтгэлийн акт үйлдэж, захиалагчид шалгуулж баталгаажуулна. • Ковш нь 110/35/10 кВ-ын Бэрх дэд станц, 110/35/6 кВ-ын Өндөрхаан дэд станц, Тахилгат 10 кВ-н ЦДАШ-ын трассын дагуу ажиллана. • Тээвэр нь механизмын зардалд ороогүй болно.

ГАЗАР ШОРООНЫ АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

Ажлын нэр	Газар шорооны ажилбар	Хэмжих нэгж	Toо	Хэмжээ	Ухах, булах газар (м ³)
Шинээр барих 110/35/10 кВ Бэрх дэд станц	Тоноглолын суурийн нүх булах	ш	25	1.2*1.2*1.6	82.87
	Газардуулгын нүх булах	м	1100	1100*0.7*0.4	261.8
	Тосны нөөц савны нүх булах	ш	1	3*7*4	71.4
	Трансформатор, хаалттай хуваарилах байгууламжийн нүх булах	ш	2	8.4*7*0.5	24.99
110/35/6 кВ Өндөрхаан дэд станцад	Тоноглолын суурийн нүх булах	ш	8	1.2*1.2*1.6	15.66
	Газардуулгын нүх булах	м	120	120*0.7*0.4	28.56
Тахилгат 10 кВ-ын ЦДАШ	Тулгуурын нүх ухах	ш	316	2.5*1.5*0.8	948
	Тулгуурын нүх булах	ш	316	2.5*1.5*0.8*0.85	805.8
	Газардуулгын шуудуу ухах	м	12640	12640*0.7*0.4	3539.2
	Газардуулгын шуудуу булах	м	12640	12640*0.7*0.4*0.85	3008
Нийт хэмжээ					8786.28

Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

ҮНİЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

БЗӨБЦТС ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Н.Тавинбэх танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], ажлыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайллан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.

4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.

7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хургуулж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.

9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. |
| 10. Зөрчил, гологдол арилгахгүй | 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна. |

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- | | |
|--|--|
| 11. Үе шатны ажлын хуваарь | 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарын тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна. |
| 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх | 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ. |
| 13. Алданги | 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарын нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй. |
| 14. Ажил дуусгах | 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. |
| Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ | |
| 15. Хүлээж авах | 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна. |
| 16. Эцсийн тооцоо | 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна. |
| 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага | 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдхөд ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.
Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоо болон гүйцэтгэлийн актыг хүлээн авснаас хойш төлбөрийг 2019 оны 12дугаар сард багтаан санхүүжилтийг олгоно.
Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай зарцуулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ.
Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дунг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана. |
| 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага | 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө. |
| | 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг сутгана. |

- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
 - 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
 - (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
 - 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
 - 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГТН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: T-XA19/28 дугаартай 110/35/10 кВ Бэрх дэд станцад тоноглол суурилуулах ажлыг гүйцэтгэх
ГТН 4.1	Ажил эхлэх өдөр: Гэрээ байгуулжс 2 тал харилцан тохиролцож гарын үсэг зурсан өдөр Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: Ажил гүйцэтгэх гэрээнд тусгана.
ГТН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 7 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГТН 9.1	Чанарын баталгаат хугацаа 90 хоног байна.
ГТН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0.1 хувь байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 10 хувь байна.
ГТН 19.1	Урьдчилгаа санхүүжилт олгохгүй. Гэрээний төлбөрийг гэрээ дүгнэсэн акт болон гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн 2019 оны 12 дугаар сард багтаан төлбөрийг барагдуулна.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)
(Албан тушаал)

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)
(Албан тушаал)

ажил гүйцэтгэх гэрээ

Дугаар № **T-XA №19-28**

Багануур дүүрэг

Нэг талаас БЗӨБЦС ТӨХК (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь ХА19/28 дугаартай 110/35/10 кВ Бэрх дэд станцад тоноглол суурилуулах ажлыг 25 тн-н даацтай автокранаар гүйцэтгэх (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өргөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал

- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;
- 5.8.** Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9.** Санхүүжилтийн хуваарь;
- 5.10.** Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- 6.** Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
- 7.** Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 8.** Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 9.** Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
 [Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
 [Утас/факсын дугаар]
 [Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
 [Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
 [Утас/факсын дугаар]
 [Харилцагч банкны нэр, дансны дугаар]